

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛ**

**2 дугаар хуралдаанаар хэлэлцсэн асуудлын тойм №2
2018.03.30**

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харъяа Идэр, Онги-Таац Онон-Улз, Хануй, Хүйсийн говь-Цэцэг нуур, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргаадын дарга (ахлах түшмэл ТЗ-8)-ын албан тушаалд сонгон шалгаруулалт явуулсан дүн, тухайн ажлын байрны албан тушаалд дүгнэлт гаргуулах, нэр дэвшүүлэх тухай	<p>1. Надмидын Болдбаатарыг Онги-Таац голын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Сүхбалын Жаргалзаяаг Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны даргын албан тушаалд, Нямдоржийн Батболдыг Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбатад санал болгож тогтоол гаргахаар тогтов.</p> <p>2. Идэр голын, Онон-Улз голын, Хануй голын сав газрын захиргааны даргын удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах нээлттэй сонгон шалгаруулалтыг дахин нээлттэй зарлахаар болов.</p>
2	Бусад асуудал /нээлттэй сонгон шалгаруулалтын тухай” /	<p>1.Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 128 дугаар тогтоолоор баталсан “Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын “Гурав”-ын 3.3-т заасны дагуу Салбар зөвлөлийн гишүүн Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, Газар зохион байгуулалт, усны нэгдсэн бодлого зохицуулалтын газрын дарга Ш.Мягмар нар өмнө нь сонгон шалгаруулалт удирдан зохион байгуулсан арга туршлагаасаа Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансарт арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллахаар болов.</p> <p>2.“Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын “Найм”-ын 8.1-т заасны дагуу Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүн, сонгон шалгаруулах комиссын бүрэлдхүүн нь төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалт явуулах, мэргэшлийн шалгалт авах, төрийн жинхэнэ албан хаагчийн эрх зөрчигдсөн болон ёс зүйн зөрчилтэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх зэрэг Салбар зөвлөлийн эрх, үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцохдоо төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж ажиллах үүрэгтэйг сануулав.</p> <p>3.Яамны харъяа байгууллагын удирдах албан тушаалд томилогдох ажилтны нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, сонгон шалгаруулалтад өрсөлдөх иргэдийн иргэний үнэмлэхийг Лавлагааны баримт бичгээр орлуулахгүй зөвхөн Монгол Улсын иргэний үнэмлэхний эх хувь байх нь зүйтэй гэж үзэв.</p>

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дугаар хуралдаан 2018 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 10 цаг 30 минутаас 301 тоот өрөөнд болов.